



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 09 сарын 12 өдөр

Дугаар А/939

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5.а, 29.2, Соёлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.1 дэх заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 26/23 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нийслэлийн нутаг дэвсгэрт хотын соёлыг төлөвшүүлэх, иргэдийн соёлыг дээшлүүлэхээр нутгийн захиргааны байгууллагуудаас хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөр, зохион байгуулж буй үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж ажиллах үүрэг бүхий "Соёлын элч"-ийг нийслэлийн 169 хороонд ажиллуулах журмыг хавсралтаар баталсугай.

2. Нийслэлийн "Соёлын элч"-ийг ажиллуулахтай холбогдолтой төсөв, санхүүжилтийг жил бүр нийслэлийн төсөвт тусгаж батлуулах ажлыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс /Э.Ганхүү/-т;

3. Энэхүү журмын хэрэгжилтийн талаарх мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд сурталчлахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хэвлэл мэдээлэлтэй харилцах хэлтэс /Ц.Мөнхбаатар/-т;

4. Захирамжийн биелэлтийг хангаж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс /М.Эрдэнэжаргал/-т, Нийслэлийн Соёл, урлагийн газар /Ч.Бат-Эрдэнэ/-т, Нийслэлийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар /Ө.Ган-Өлзий/-т тус тус үүрэг болгосугай.

5. Энэ захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газар /Э.Содномжамц/-т даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ

С.АМАРСАЙХАН

111020004306

Нийслэлийн Засаг даргын 2019 оны
09 сарын 12-ны өдрийн
А/939-р захирамжийн хавсралт

НИЙСЛЭЛИЙН СОЁЛЫН ЭЛЧИЙГ АЖИЛЛУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь нийслэлийн нутаг дэвсгэрт хотын соёлыг төлөвшүүлэх, иргэдийн соёлыг дээшлүүлэхээр нутгийн захиргааны байгууллагуудаас хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөр, зохион байгуулж буй үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэн ажиллах үүрэг бүхий нийслэлийн 169 хорооны "Соёлын элч"-ийн эрх, үүрэг, үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Нийслэлийн "Соёлын элч" нь Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн батламжилсан төлөөлөгч байх бөгөөд тухайн хорооны нутаг дэвсгэрт ажиллаж, амьдарч буй иргэд, хүүхэд залуучууд олон нийтэд чиглэсэн соён гэгээрүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах сайн дурын ажилтан байна.

Хоёр. Нийслэлийн "Соёлын элч"-ийг сонгон шалгаруулах

2.1. Нийслэлийн "Соёлын элч"-ийн сонгон шалгаруулалтыг нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс, нийслэлийн Соёл, урлагийн газар, нийслэлийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, нийслэлийн 9 дүүргийн Засаг даргын Тамгын газраас хамтарсан ажлын хэсэг гарч зохион байгуулна.

2.1.1. Сонгон шалгаруулалтын удирдамжийг ажлын хэсгээс боловсруулан нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дарга баталж, иргэд, олон нийтийн дунд нээлттэй зохион байгуулах бөгөөд шалгарсан иргэдийн нэрсийг ажлын хэсгээс нэгтгэж, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчид уламжилж батлуулна.

2.2. Нийслэлийн "Соёлын элч" нь дараах шаардлагыг хангасан байна.

2.2.1. Боловсрол, соёл, урлаг, спорт, хүмүүнлэгийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байсан, тухайн хорооны иргэдийн хүндлэлийг хүлээсэн, олонд танигдсан, үлгэр дуурайлал болсон 18-аас дээш насны иргэн байх;

2.2.2. Нийслэлийн "Соёлын элч"-ийн сонгон шалгаруулалтын ажлын хэсгээс гаргасан удирдамж болон энэ журмын 2.2.1 дүгээр заалтын шаардлагыг хангаж, сонгон шалгаруулалтад тэнцсэн иргэн байх;

2.3. Нийслэлийн "Соёлын элч"-ийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулсан ажлын хэсэг "Соёлын элч"-ээр ажиллахаар сонгогдсон иргэдийн нэрсийг тав хоногийн дотор нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчид уламжилж батламжлах эсэх шийдвэрийг гаргуулна.

2.4. Нийслэлийн "Соёлын элч"-ийн батламжлагдан ажиллах хугацаа зургаан жил байна.

2.5. Нийслэлийн "Соёлын элч"-ийн батламжлагдан ажиллах хугацааг дараах тохиолдолд дуусгавар болсонд тооцно.

2.5.1. Батламжлагдан ажиллах хугацаа дуусгавар болсон;

2.5.2. Үүрэгт ажлаа гүйцэтгэх боломжгүй болсон тухайгаа өргөдлөөр гэрээ байгуулсан байгууллагуудад ирүүлсэн эсхүл эрх зүйн чадамжгүй болсон нь тогтоогдсон буюу шүүхээр ял шийтгэл ноогдуулсан;

2.5.3. Гадаад улсад гурав болон түүнээс дээш сараар ажиллаж, амьдрах болсон;

2.5.4. Хорооны Засаг дарга тухайн хорооны "Соёлын элч"-ээр ажиллаж буй иргэнийг үүрэгт ажлаас нь чөлөөлүүлэх хүсэлтээ дүүргийн Засаг даргад бичгээр уламжлах бөгөөд дүүргийн Засаг дарга дэмжиж чөлөөлүүлэх тухай албан бичиг нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчид хүргүүлж шийдвэрийг гаргуулсан;

Гурав. "Нийслэлийн Соёлын элч"-ийн эрх, үүрэг

3.1. Нийслэлийн "Соёлын элч" нь нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн батламжилснаар "Андгай" өргөж, "Батламж" гардан авснаар дараах эрх эдэлнэ.

3.1.1. "Соёлын элч" нь нийслэлийн Соёл, урлагийн газар, нийслэлийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газартай байгуулсан гурван талт гэрээний хүрээнд дүүргийн Засаг даргын Тамгын газар, Хорооны Засаг дарга болон бусад төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах;

3.1.2. Санаачлан зохион байгуулж буй ажил хэрэг, үйл ажиллагааг төрийн байгууллагад уламжилж дэмжүүлэх, иргэд, олон нийтэд нийслэлийн Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтсээр дамжуулан хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр түгээлгэж сурталчлах.

3.1.3. Нийслэлийн Соёл, урлагийн газар, нийслэлийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газартай байгуулсан гэрээг улирал тутамд Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсээс тусгайлан гаргасан дүгнэх удирдамжийн дагуу дүгнүүлэн, үр дүнгийн хувьтай тэнцэх хэмжээний урамшуулал авах.

3.2. Нийслэлийн "Соёлын элч"-нь дараах үүрэг хүлээнэ.

3.2.1. Нийслэлийн Соёл, урлагийн газар, нийслэлийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газартай байгуулсан гурван талт гэрээний хэрэгжилтийг хангаж ажиллах.

3.2.2. Ажлын тайланг улирал бүрийн дараа сарын 05-ны өдрийн дотор гурван талт гэрээ байгуулсан байгууллагуудад бичгээр болон цахим хаягаар ирүүлж дүгнүүлэх.

3.2.3. Нийслэлийн "Соёлын элч"-нь үйл ажиллагааг ил тод, нээлттэй явуулж иргэдийг бүтээлч, гэгээлэг санал санаачилгад уриална. Тухайлбал:

- "Хотын соёл"-ыг төлөвшүүлэх, иргэдийн соёлыг дээшлүүлэх,
- Хүүхдийн эрх, хөгжил, хамгаалал, аюулгүй байдал, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх,
- Иргэдийг ажиллаж, амьдарч буй орчиндоо хотын соёлыг түгээхэд нь дэмжлэг үзүүлж ажиллах,
- Иргэдийн хотын хөгжилд хувь нэмрээ оруулах, хийж бүтээх үйл хэрэг, санал санаачилгыг нь дэлгэрүүлэх, дэмжих,
- Залуучуудын зөв хандлага, хэвшил
- Иргэдийн эрүүл амьдралын хэв маяг, хэвшил,
- Гэр бүлийн эерэг харилцаа, хандлага

3.2.4. Нийслэлийн “Соёлын элч” нь жил бүрийн 12 дугаар сард тухайн хорооны иргэд, олон нийтэд ажлаа тайлагнана.

Дөрөв. Удирдлага, зохион байгуулалт

4.1. Нийслэлийн “Соёлын элч” нь батламжлагдан ажиллах хугацаандаа хийж гүйцэтгэх ажлын талаар нийслэлийн Соёл, урлагийн газар, нийслэлийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газартай жил бүр гурван талт гэрээ байгуулж ажиллана.

4.2. Нийслэлийн “Соёлын элч”-ийн хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөөг гэрээний хавсралт болгон тодорхой заасан байна.

4.3. Нийслэлийн “Соёлын элч”-тэй байгуулах гурван талт гэрээг нийслэлийн Соёл, урлагийн газар, нийслэлийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар хамтран боловсруулж, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсээр хянуулан нийслэлийн Засаг даргын тухайн асуудал хариуцсан орлогчоор батлуулна.

4.4. Нийслэлийн “Соёлын элч” нарын ажил, байдлыг дүгнэхдээ нийслэлийн Соёл, урлагийн газар, нийслэлийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газартай байгуулсан гурван талт гэрээг үндэслэн идэвх санаачилга, ажлын гүйцэтгэл, үр дүн зэргийг харгалзан улирал тутамд Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсээс тусгай удирдамж гарган дүгнэнэ.

4.5. Нийслэлийн “Соёлын элч”-ийг ажиллуулахтай холбогдолтой төсөв, санхүүжилтийн тооцоог жил бүр нийслэлийн төсөвт суулгаж батлуулах ажлыг нийслэлийн Соёл, урлагийн газар хариуцах бөгөөд “Соёлын элч” нарт тухай бүрт олгох ажлыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс, дүүргүүдийн Засаг дарга нар хариуцан ажиллана.

4.6. Нийслэлийн “Соёлын элч”-ийг аливаа үйл ажиллагаа зохион байгуулах, ажил гүйцэтгэхэд нь Хороо болон дүүргийн Засаг дарга нар дэмжлэг үзүүлэн ажиллана.

4.7. Нийслэлийн “Соёлын элч”-ийн гүйцэтгэх ажлын батлагдсан төлөвлөгөөг холбогдох байгууллагуудад хүргэх, нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг нийслэлийн Соёл, урлагийн газар хариуцна.

Тав. Соёлын элчид хориглох зүйлс

5.1. Шашны байгууллагын үйл ажиллагааг сурталчлах;

5.2. Улс төрийн намын гишүүд, дэмжигчидтэйгээ хийх уулзалт болон тэдгээрээс зохион байгуулж буй өдөрлөг, сонгуулийн сурталчилгаанд оролцох;

5.3. Хувийн ашиг сонирхолд нийцүүлэн үйл ажиллагаа явуулах;

5.4. Иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн хандив, тусламжийг зориулалтын бусаар зарцуулах;

5.5. Улс төрийн нам эвсэл, нэр дэвшигчдийг аливаа хэлбэрээр сурталчлах;

5.6. Нийслэлийн “Соёлын элч”-д хууль, журам, гэрээгээр хүлээлгэсэн үүрэгт нь үл хамаарах ажил, үүрэг гүйцэтгүүлэхийг хориглоно.

Зургаа. Соёлын элчийг дэмжих, урамшуулах, дүгнэх

6.1.Нийслэлийн “Соёлын элч” нарын ажил, байдлыг нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсээс тусгайлан гаргасан дүгнэх удирдамжийн дагуу дүгнэж, үр дүнгийн хувийг тогтоон олгоно.

6.2.Нийслэлийн “Соёлын элч”-ийг ажиллуулах журам батлагдсантай холбогдуулан “Соёлын элч”-ээр ажиллах иргэдийн сонгон шалгаруулалтыг энэ журмын 2.1, 2.2 дугаар заалтын дагуу явуулах бөгөөд сонгон шалгаруулалтад шалгарсан иргэдийг шагнаж урамшуулах зардлыг тухайн жилийн батлагдсан төсвөөс гаргана.

Долоо. Хүлээлгэх хариуцлага

7.1.Энэ журмыг зөрчсөн гэм буруутай этгээдэд холбогдох хууль, тогтоомжийн дагуу хариуцлага тооцно.